

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 2 2021 оны 11-р сар


ЖИШИГ ТӨСЛИЙН I ҮЕ ШАТ

ЭРХЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ БА ЛАВЛАХ ХҮСНЭГТ БОЛОВСРУУЛАЛТ

Салхитын ордын хаалтын менежментийн төлөвлөгөө (ХМТ) боловсруулах I үе шатанд төлөвлөсөн Эрх зүйн орчны шинжилгээг хийж, Лавлах хүснэгтийг боловсруулав. Уг хүснэгтэд Монгол улсад уурхайн хаалтын менежментийг зохицуулж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын шаардлагуудыг багцлан, хүснэгт хэлбэрээр нэгтгэн харуулахыг зорив.

■ ЭРХЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Төслийн Үндэсний болон Канад зөвлөхүүдийн хамтарсан баг уурхайн ХМТ боловсруулахтай холбоотой хууль, эрхзүйн шаардлагуудыг судалж дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар баталсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам” ба “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” зэрэг дагалдах журмуудыг судалж, холбогдох эрх зүйн шаардлагуудыг тодорхойлов. Мөн Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн Салхит төслийн ТЭЗҮ, БОНБНУ, БОМТ зэрэгт бичиг баримтын судалгааг хийлээ.



■ ЛАВЛАХ ХҮСНЭГТ

Зөвлөх баг Салхитын ХМТ боловсруулах эрх зүйн орчинг үнэлсний дүнд хууль эрх зүйн шаардлагуудыг нэгтгэсэн “Лавлах хүснэгт” боловсруулав. Лавлах хүснэгт буюу “Concordance/Cross Reference Table”-ийг Канад, АНУ зэрэг улсад байгалийн баялаг ашиглах, боловсруулах төслийн зөвшөөрөл хүсэж буй болон хүлээн авч шийдвэрлэж буй талууд бичиг баримтын бүрдлийг шалгах хэрэгсэл байдлаар ашигладаг. Хүснэгтэд эрхзүйн шаардлагуудыг жагсааж, холбогдох мэдээллийг бичиг баримтын аль бүлэг, хэсэгт тусгасан болохыг товъёолох нь төрийн байгууллагуудын бичиг баримтын бүрдэл шалгах, материал хүлээж авах ажлыг хөнгөвчлөхийн зэрэгцээ төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүд материал бүрдүүлэлтээ урьдчилан хянах боломжийг олгоно.

УУРХАЙН ХААЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

Р. Л. Нобле-Паттинсон, M.E.Des., EP

Дэлхий дахинд уул уурхайн салбар байгаль орчин, нийгмийн өмнө хариуцлагатай байхыг улам ихээр шаарддаг болсон өнөө үед оролцогч талууд, ялангуяа Засгийн газар, төсөл хэрэгжүүлэгч, нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэд хариуцлагатай уурхайн хамгийн чухал хөшүүрэг болох уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн гүйцэтгэлд өндөр ач холбогдол өгөх болсон.

■ КАНАД УЛСЫН ТУРШЛАГА

Канад нь арван муж, гурван хязгаар нутгаас бүрдсэн Холбооны улс юм. Канад улс газар зүй, геологийн хувьд баялаг тогтоц бүхий өргөн уудам нутагтай, эрчим хүчний болон металлургийн нүүрс, уран, алмаз, үнэт чулуулаг, элсний эрдсүүд, алт, поташ, зэс, хөнгөн цагаан, төмөр, никел, кобальт гэх мэт их олон төрлийн эрдэс баялаг олборлодог.

Холбооны улсын хувьд муж, хязгаар нутаг тус бүр уул уурхайн салбарт харилцан адилгүй хууль, эрх зүйн орчинг бүрдүүлсэн байдаг бөгөөд ихэвчлэн уурхайн амьдралын мөчлөгт суурилсан зохицуулалтыг хэрэгжүүлдэг байна. Муж, хязгаар нутгууд уул уурхайн хөгжлийн үе шат, хүн амын бүтэц ба нягтшил, төсөв санхүүгийн бодлого, байгаль, цаг уурын нөхцөл байдал зэрэг өөрсдийн онцлогийг харгалзсан хууль тогтоомжийг мөрдүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нийтлэг зарчмыг баримталдаг. Төсөл хэрэгжүүлэгчид ашигт малтмалын хуулиас гадна тухайн муж, хязгаар нутагт хүчин төгөлдөр үйлчилж буй байгаль орчны хууль тогтоомжийг мөн адил биелүүлсэн байхыг шаарддаг. Канад улсын хувьд байгаль, цаг уурын олон янзын экосистем бүхий бүс, бүслүүрийг хамардаг учир нэн тэргүүнд уул уурхайгаас байгаль, экологид үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлдэг. Түүнчлэн, Холбооны Засгийн газраас хүрээлэн буй орчны чанар, аюулгүй байдлын үндэсний стандартуудыг баталж улс даяар мөрдүүлдэг байна.

■ ОЛОН УЛСЫН УУЛ УУРХАЙН ТОМООХОН БАЙГУУЛЛАГУУД БА ТЭДНИЙ ЗӨВЛӨМЖ ЧИГЛЭЛ

Дэлхий нийтэд уурхайг тогтвортой, үр өгөөжтэй байдлаар хаахад ихээхэн анхаарах болсон учир Уул уурхайн олон улсын байгууллагууд бүс нутаг болон хэд хэдэн улсыг хамарсан төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, сайн туршлага бий болгох, жишиг шаардлагуудыг улс орнуудын хууль, эрх зүйн орчинд нэвтрүүлэхийг зорьдог. Олон улсын зарим уул уурхайн байгууллагуудаас дурдвал:

► **Олон улсын уул уурхай, металлургийн Зөвлөл** “Уурхайн хаалтын тэргүүн туршлага” гарын авлагыг боловсруулж уурхайн амьдралын мөчлөгийн бүхий л үе шатанд уурхайн хаалтыг хэрхэн оновчтой төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг багтаасан (ICMM, 2019). Энэхүү гарын авлагад уурхайн хаалтад баримтлах зарчмууд ба үнэт зүйлсийг тодорхойлж, хаалтын менежментийн үндсэн асуудлууд болох нийгмийн асуудал, хаалтын зорилго, зорилтууд, эрсдэлийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон нөхөн сэргээлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ ба баримтжуулалт гэх мэт нийт 12 арга, аргачлалыг санал болгожээ.

Эхийг <https://www.icmm.com/en-gb/guidance/environmental-stewardship/integrated-mine-closure-2019>-ээс үзнэ үү.

► **Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын** Уул уурхайн ажлын хэсгээс хууль тогтоогч нарт зориулан уурхайн хаалтын эрх зүйн орчны давхардал ба хийдлийг хэрхэн үнэлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох алхамчилсан удирдамж бүхий “Засгийн газруудад зориулсан Уурхайн хаалтын хяналтын хуудас” гарын авлагыг боловсруулж, нийтийн хүртээл болгосон (АРЕС, 2018). Тус ажлын хэсэг эрдэс баялгийн засаглал харьцангуй өндөр хөгжсөн орнуудтай хамтран, тухайн улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Эхийг: <https://www.apec.org/publications/2018/03/mine-closure-checklist-for-governments>

► **Канадын уул уурхайн үндэсний ассоциаци** тус улсад эрдэс баялаг олборлох, тоног төхөөрөмж болон бусад үйлчилгээ үзүүлдэг компаниудыг эгнээндээ нэгтгэсэн, нөлөө бүхий байгууллага бөгөөд “Тогтвортой уул уурхай санаачилга (ТУУС)”-ыг манлайлан хэрэгжүүлдэг. ТУУС-ын протоколууд болон шалгуур үзүүлэлт бүхий үнэлгээний системийн дагуу гишүүд нь жил бүрийн гүйцэтгэлийн тайлангаа цахим сандаа нээлттэй байршуулдаг байна. ТУУС-д нэгдсэн компаниуд хариуцлагатай уурхайн стандарт, жишигийг олон улсын түвшинд бий болгох санаачилгуудыг манлайлж хэрэгжүүлдэг байна. Дэлгэрэнгүй: http://mining.ca/sites/default/files/documents/TSM_Mine_Closure_Framework.pdf, and <https://mining.ca/towards-sustainable-mining/protocols-frameworks/>

► **“Уурхайн Хаалт” олон улсын хурал** жил бүр зохион байгуулагдаж, уурхайн хаалтын чиглэлээр дэлхийд тэргүүлэх шилдэг мэргэжилтнүүд цугларч сүүлийн үеийн судалгааны дүн, мэдлэг мэдээлэл, туршлагаа солилцдог чухал ач холбогдолтой арга хэмжээ болдог. Засгийн газрууд болон уул уурхайн корпорациуд энэхүү олон улсын хурлаас суралцаж, олж авсан мэдлэг мэдээллийг бодлого төлөвлөлтөө тусгаж, хэрэгжүүлэх боломжтой.

ХОЛБОО БАРИХ

Жишиг төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн дэд захирал Р.Алтангэрэл

✉ r.altangerel@merit.mn хаягаар холбогдоно уу.